



ХОТ БАЙГУУЛАЛТ,
БАРИЛГА,
ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТЭД 2024 ОНЫ БАЙДЛААР
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ.
2024 он

**“АЛСЫН ХАРАА-2050” МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ХӨГЖЛИЙН
БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТЭД 2024 ОНЫ БАЙДЛААР
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2024.09.19.

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтэд 2024 оны байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж хүргүүлэх, холбогдох мэдээллээр хангах зорилгоор хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Энэхүү ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206, 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг үндэслэл болгов.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогод туссан Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах 10 зорилтын хүрээнд 44 арга хэмжээг хэрэгжүүлэн ажилласан байна.

Энэхүү урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилтэд 2024 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд хэрэгжилт **75,2 хувь**, **“тодорхой үр дүнд хүрсэн”** гэж үнэллээ.

Бодлогын баримт бичигт тусгагдсан нийт 44 арга хэмжээнээс 100%-тай 12; 90%-тай 5; 70%-тай 15; 50%-тай 8, 30%-тай 2 арга хэмжээ, биелэлт гарах боломжгүй хамааралгүй үнэлэх боломжгүй /ҮБ/ 2 арга хэмжээ байна.

“Алсын хараа -2050” хөгжлийн бодлогын хэрэгжилтийн түвшин харуулбал:

Хүснэгт-1

№	Гэрээнд туссан арга хэмжээ	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн түвшин						Хамааралгүй заалт /ҮБ/	Хэрэгжилтийн хувь
			100 %	90%	70%	50%	30%	0%		
1	Арга хэмжээ	44	12	5	15	8	2	-	2	75,2 %

Алсын хараа-2050 бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг арга хэмжээ тус бүрээр харуулбал:

№1	Бодлого											
	2		3		3		4		5		6	
	Хүний хөгжил	Гүйцэтгэл хувь	Амьдралын чанар ба дундаж	Гүйцэтгэл хувь	Эдийн засаг	Гүйцэтгэл хувь	Засаглал	Гүйцэтгэл хувь	Ногоон хөгжил	Гүйцэтгэл хувь	Улаанбаатар ба дагуул хот	Гүйцэтгэл хувь
1	2.5.1	70	3.2.1	100	4.2.7	50	5.3.5	100	6.3.14	90	9.2.33	30

2	2.5.2	30	3.2.2	70	4.2.8	70			6.4.7	50	9.3.1	70
3	2.5.3	50	3.2.3	100	4.2.19	100			6.4.10	100	9.3.3	70
4	2.5.4	50	3.2.4	70	4.2.24	ҮБ			6.4.21	50	9.3.4	90
5	2.5.5	50	3.2.5	70					6.4.22	70	9.3.38	90
6	2.5.6	100	3.2.6	70					6.4.23	90	9.5.2	100
7	2.5.7	100	3.2.7	70							9.5.3	90
8	2.5.10	100	3.2.8	100								
9	2.5.11	70	3.2.9	70								
10	2.5.12	100	3.2.10	100								
11			3.2.11	50								
12			3.2.12	50								
13			3.2.13	70								
14			3.2.14	70								
15			3.2.15	70								
16			3.6.8	ҮБ								

Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн хүрээнд 2024 оны байдлаар “Эрчимжүүлэх шаардлагатай” 50%-ийн хэрэгжилттэй 8, “Үр дүнгүй” 30%-ийн хэрэгжилттэй 2, нийт 10 ажил байна.

Хэрэгжилт “Эрчимжүүлэх шаардлагатай” 50% биелэлттэй дараах 8 ажил байна. Үүнд:

1. 2.5.3. Хот, суурин газрын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн шугам сүлжээнд холбогдсон амины орон сууцны хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлнэ;

2. 2.5.4. Орон сууцны халаалт, эрчим хүчний эх үүсвэрийг сэргээгдэх эрчим хүчээр хангана;

3. 2.5.5. Нэг хүнд ногдох ногоон байгууламжийн хэмжээг үе шаттайгаар нэмэгдүүлж дэлхийн жишигт хүргэнэ;

4. 3.2.11. Худалдан авах чадварт нийцсэн өртөгтэй орон сууцны хэрэгцээг хангахад чиглэгдсэн хуримтлалтай дүйцүүлэх хөрөнгө оруулалт, хөнгөлөлтийн санг хослуулсан ипотекийн зээлийн уян хатан, олон хувилбарт бодлогыг хэрэгжүүлнэ;

5. 3.2.12. Ногоон орон сууцыг нэвтрүүлэх бодлогын болон санхүүгийн дэмжлэгийн тогтвортой тогтолцоог бүрдүүлнэ;

6. 4.2.7. Барилгын материал, мал, амьтны гаралтай болон уул уурхайн түүхий эдийг боловсруулж, эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг урамшуулах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ;

7. 6.4.7. Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлж, Монгол Улсын тодорхойлсон хувь нэмэр (NDC) баримт бичгийн хэрэгжилтийг хангаж, сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэн, эрчим хүч, хөдөө аж ахуй, барилга, тээвэр, аж үйлдвэр, хог хаягдлын салбарын хүлэмжийн хийн ялгарлыг бууруулна;

8. 6.4.21. Барилга, зам, тээврийн салбарын хатуу хог хаягдлыг байгаль орчинд халгүй аргаар устгах, дахин боловсруулах үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлнэ.

Хэрэгжилт “Үр дүнгүй”, 30 хувьтай биелэлттэй дараах 2 ажил байна. Үүнд:

1. 2.5.2. Орон сууцны чанар, стандартыг ханган, гал түймэр, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт үзэгдэлд тэсвэртэй байх нөхцөлийг бүрдүүлнэ;

2.9.2.33. Хотын барилга байгууламжийг паспортжуулах, тэдгээрийн чанар, насжилтыг тодорхойлох, газар хөдлөлтийн үед тэсвэрлэх чадварт хянан баталгаажуулалт хийх, эрсдэлтэй байгууламжийг хүчитгэх, эсвэл буулгаж шинэчлэн барилгажуулах ажлыг зохион байгуулна.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт 2024 оны байдлаар **75,2** хувьтай, **“тодорхой үр дүнд хүрсэн”** гэж үнэлэв.

Энэхүү бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хот байгуулалт, барилгын салбарын бүх төрлийн тусгай зөвшөөрөл, мэргэжлийн эрх олгох, сунгах, нөхөн олгох, хүчингүй болгох, хянан шийдвэрлэх, хяналт тавих үйл ажиллагаа, ундны усны чанарын нэгдсэн мэдээллийн санг 100 хувь цахим хэлбэрт шилжүүлсэн.

Үндэсний орон сууцжуулалтын тухай хуулийн хэрэгцээ, шаардлагын тандан судалгааг боловсруулж, зорилтот бүлгийн иргэдийг төлбөрийн чадварт нийцсэн хямд үнэтэй, чанартай орон сууцаар хангах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах, цогц тогтолцоог бий болгох шаардлагатай гэж дүгнэн, холбогдох хуулийн төслийн хамт Засгийн газрын 2024 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэгдэн дэмжигдэж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсэн.

Тус яамнаас Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг Засгийн газрын 2022.04.06-ны өдрийн 143-р тогтоолоор; Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэр дэх “Чингис хаан” шинэ нисэх онгоцны буудлыг түшиглэн Хөшигийн хөндийн Эдийн засгийн чөлөөт бүсийг байгуулах асуудлыг УИХ-ын 2022.04.07-ны өдрийн 10 дугаар тогтоолоор; Төрийн захиргааны зарим байгууллагын ажиллах нэгдсэн байрыг Төв аймгийн Хөшигийн хөндий рүү нүүлгэн шилжүүлэх асуудлыг Засгийн газрын 2022.03.09-ний өдрийн 98 дугаар тогтоолоор тус тус батлуулсан.

Засгийн газрын 2022.04.06-ны өдрийн 143-р тогтоолоор баталсан Шинэ Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хүрээнд орон сууц, олон нийт, худалдаа, үйлчилгээний бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, эдийн засгийн чөлөөт бүсийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, тээвэр, ложистикийн төвийн ТЭЗҮндэслэл болон эхний ээлжийн инженерийн бэлтгэл арга хэмжээ, ус хангамж, холбоо дохиолол, дулаан, цахилгаан хангамж, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламжийн зураг төслийг боловсруулж, батлуулах ажлыг шуурхай зохион байгуулж ажилласны үр дүнд Хөшигийн хөндийд байрлах олон улсын нисэх онгоцны буудлыг даган байгуулагдах “Шинэ Зуунмод” хотын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх боломж бүрдсэн байна.

Гадаадын зээл, тусламжаар Улаанбаатар хот болон 16 аймгийн төв, 2 сумын төвд бохир ус цэвэрлэх байгууламж шинээр барих ажлуудыг зохион байгуулсан. Үүнд: БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлээр Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийг, АХБ-ны зээлээр 10 аймгийн 12 сумын, БНФУ-ын зээлээр “Эрдэнэт хотын цэвэрлэх байгууламжийг, БНПУ-ын зээлээр 5 аймгийн төвийн бохир ус цэвэрлэх байгууламжийг шинээр барих төслүүдийг хэрэгжүүлж байна.

"Сумын хөгжил: Инженерийн дэд бүтцийн хангамж" төсөл, арга хэмжээний хүрээнд 18 суманд бохир ус цэвэрлэх байгууламж шинээр барих төслийг тус тус хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд байгуулсан санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийн дагуу Нийслэлд хэрэгжүүлж буй "Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр" төсөл нь 10 жилийн хугацаанд 3 үе шаттайгаар Сэлбэ, Баянхошуу, Дамбадаржаа, Дэнжийн 1000, Толгойт, Шархад дэд төвүүдийг байгуулна.

Төрийн өмчийн түрээсийн орон сууцны санг нэмэгдүүлэх хүрээнд 2024 оны байдлаар улс, нийслэлийн төсөв, олон улсын хөгжлийн санхүүжилт, төр-хувийн хэвшлийн түншлэлээр орон сууцны хороолол барих 8 төслийг хэрэгжүүлж байна. Уг төслүүд хэрэгжсэнээр нийт 217.27 га талбайд 2027 он хүртэлх хугацаанд нийт 28,185 айлын орон сууц ашиглалтад орно. Хувийн хэвшлийн ашиглалтад оруулсан орон сууц 2021 онд 17478, 2022 оны байдлаар 23,201, 2023 онд 19,196, 2024 оны эхний хагас жилд 8,347, нийт 68,222 айлын орон сууц байна.

ДӨРӨВ. САНАЛ, ЗӨВЛӨМЖ

1. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт туссан хэрэгжилт хангалтгүй 50%-тай 8, 30%-тай 2, нийт 10 арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээ авч ажиллахыг газрын дарга нарт даалгах;

2. Санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдээгүйн улмаас хэрэгжилт хангалтгүй арга хэмжээний санхүүжилтийг улс, орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрээс шийдвэрлүүлэх боломжийг судлан хэрэгжүүлж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар болон холбогдох газрын дарга нарт үүрэг болгох;

3. Бодлогын баримт бичигт туссан яамны хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг эзэнжүүлэх, хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудын уялдаа, холбоог сайжруулж, биелэлтийн үнэн зөв, нотлох баримтын бүрдүүлэлтийг хангаж, 2000 тэмдэгтэд багтаан тайлагнаж байхыг Төрийн нарийн бичгийн дарга /С.Төмөрхүү/, газар, хэлтсийн дарга нарт үүрэг болгох;

4. Урт хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан тухайн яамны хариуцан хэрэгжүүлэх боломжгүй арга хэмжээнүүд /3.6.8, 4.2.24/ биелэлтэд орж ирж байгааг холбогдох хариуцсан байгууллагад шилжүүлэхэд анхаарч эцэслэх;

5. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын биелэлтийг үнэлэхэд хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт байхгүй тул үнэлгээг хийхэд хүндрэлтэй байгаа тул Засгийн газрын 2020 оны 206-р тогтоолын баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 1-р хавсралтад заасан тайлагнах хугацаагаар зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг тодорхойлон батлах нь зүйтэй гэсэн саналтай байна.

**ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН ЯАМ,
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР**